



## ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГГИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монголбанкинд гадаадын зээл, тусламжаар дараах төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна:

1. Сангийн яам, Дэлхийн банк хооронд 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан “Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл” нь санхүүжилтийн гэрээнд заасны дагуу С2 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Монголбанкны зохицуулалтын чадавхийг бэхжүүлэх үүднээс санхүүгийн салбарын макро зохистой хяналт шалгалтыг бий болгож сайжруулах, Базел II болон III журам заавруудад нийцүүлэн журмуудыг шинэчлэн хэрэгжүүлэх ажлыг хурдасгах, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцсэн банкны нягтлан бодох бүртгэлийн журмыг боловсруулж хэрэгжүүлэх үндсэн зорилготой бөгөөд уг төсөл нь 2016 оны 6 дугаар сарын 31-ний өдөр хэрэгжиж дуусна.

Төслийн хүрээнд банкуудад мөрдүүлэх Нягтлан бодох бүртгэлийн багц материалын төслийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, батлуулсан бөгөөд 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн банкууд мөрдөж эхлэхээр болсон. Иргэдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан амжилттай хэрэгжүүлж байна. Мөн уг ажлын хүрээнд “Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь”-ийг боловсруулан 2500 хувь хэвлүүлж олон нийтэд тараасан бөгөөд тус толийг олон нийтэд илүү хүртээмжтэй болгох үүднээс цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн. ([www.glossary.mn](http://www.glossary.mn))

Одоогийн байдлаар уг төслийн санхүүжилтээр арилжааны банкуудын мөрдөж буй журам заавруудыг шинэчлэх болон банк, санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэл нь банкуудад нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох зорилготой стресс тест боловсруулах чиглэлээр дотоодын болон олон улсын зөвлөх авч ажиллуулж байна.

2.Монголбанк нь банк, санхүүгийн салбарын төлбөр тооцооны системийг шинэчлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэх гэж байна. Энэхүү төсөл нь 2016 оноос эхлэн 36 сарын хугацаанд хэрэгжиж дуусахаар төлөвлөж байна. Одоогоор төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулах болон бусад бэлтгэл ажлууд хийгдэж байна.

МОНГОЛБАНК